



**БАТЛАН ХАМГААЛАХЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

**Сонгон шалгаруулах
журам шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар зарлигаар баталсан "Цэргийн дотоод албаны дүрэм"-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсэг, Батлан хамгаалахын сайдын 2026 оны А/305 дугаар тушаалаар баталсан "Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дүрэм"-ийн 9.3, 9.5.6, 9.6.2 дахь заалт, Захиргааны зөвлөлийн 2026 оны VII хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Төвийн дарга, эрдэм шинжилгээний ажилтан бусад ажилтан албан хаагчдыг сонгон шалгаруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмыг 2026 оны 8 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Төвийн дарга, эрдэм шинжилгээний ажилтан бусад ажилтан албан хаагчдыг сонгон шалгаруулах журмыг батлагдсантай холбогдуулан Захирлын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/11 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга (хошууч У.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАХИРАЛ
ХУРАНДАА



Т.МӨНХ-ОРГИЛ



١٥٤٧

2026	9	10	11
04	05	06	07
28	29	30	31

[illegible][illegible]

... في نفس الحسم ن دودو امر و ا فقتن مني لمر و ددو - و بعض المر مدلس مستسو يحتملهم...

[illegible]

۹۔ صاحبک مر محمديز دن رستو . زبیر مکتوب مکسوس دن صف حرکت . محمديز زندر ولسا هر صحتاً
 (اصولتور به) - د مشتيتيشتن ..

117145672
8238310

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний
хүрээлэнгийн захирлын 2020 оны 08 дугаар
сарын 12-ны өдрийн 162 дугаар
тушаалын хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
НЭГЖ ДАРГА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН БУСАД АЖИЛТАН АЛБАН
ХААГЧДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

1. Энэхүү журмын зорилго нь Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (цаашид хүрээлэн гэх)-д тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах үүрэг гүйцэтгэх нэгжийн дарга /цаашид Төвийн дарга гэх/, эрдэмтэн, судлаач, инженер техникийн ажилтан лаборатори эрхлэгч гэх мэт ажилтан албан хаагчдыг хүрээлэнд анх ажилд авахдаа хүний нөөцийн сонгон шалгаруулалт зохион байгуулах, шалгаруулалт явуулах ажлын хэсгийн чиг үүрэг болон сонгон шалгаруулалттай холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.

2. Хүрээлэнгийн тайван цагийн орон тооны дагуу эрдэм шинжилгээний ажилтныг сонгон шалгаруулах, гэрээт судлаач, цэргийн албан хаагчийн томилгоонд дээд шатны байгууллагад санал өгөхдөө энэхүү журмыг баримтлах бөгөөд заагдсан шаардлагыг хангасан ажилтныг захирлын тушаалаар томилно.

Нэг. Сонгон шалгаруулалтад оролцогчид тавигдах шаардлага

1. Хүрээлэнгийн нэгжийн даргад дээд шатны байгууллагаас томилогдох албан тушаалтанд болон лабораторийн дарга, туршилт судалгааны лабораторийн тасгийн дарга, инженер, бусад нэгжийн эрдэм шинжилгээний ажилтанд нэр дэвшигч ажилтан, цэргийн албан хаагч нарт дараах шаардлага тавина. Үүнд:

1.1. Төвийн даргад тавигдах шаардлага:

- 1.1.1. Доктор, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- 1.1.2. Шинжлэх ухаан, технологийн төсөл суурь болон хавсарга судалгааны ажил, эрдэм шинжилгээний хурал, семинар удирдан зохион байгуулсан туршлагатай байх;
- 1.1.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл 8-аас доошгүй бичиж нийтлүүлсэн байх;
- 1.1.4. Шинжлэх ухаан технологийн төсөл, суурь болон хавсарга судалгааны ажлын гүйцэтгэгчээр ажиллах чадвар, арга зүй эзэмшсэн байх;
- 1.1.5. Компьютер, техник, хэрэгслийг хэрэглээний түвшинд бүрэн эзэмшсэн байх;
- 1.1.6. Тухайн ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу 2-оос доошгүй гадаад хэлийг эзэмшсэн байх;
- 1.1.7. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, бусдыг үлгэрлэн манлайлах, удирдан чиглүүлэх чадвартай байх;
- 1.1.8. Сурах бичиг, гарын авлага, ном, нэг сэдэвт бүтээл бичиж байсан туршлагатай байх;
- 1.1.9. Аливаа баримт бичгийг стандарт, шаардлагын дагуу үг, үсэг, утга найруулгын алдаагүй боловсруулах чадвартай байх.

- 1.2. Офицер буюу алба хаагчийн орон тоонд томилогдох эрдэм шинжилгээний ахлах ажилтанд тавигдах шаардлага:
 - 1.2.1. Магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
 - 1.2.2. Шинжлэх ухаан, технологийн төсөл суурь болон хавсарга судалгааны ажил, эрдэм шинжилгээний бага хурал, семинар удирдах арга барил эзэмшсэн байх;
 - 1.2.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл 5-аас доошгүй бичиж нийтлүүлсэн байх;
 - 1.2.4. Шинжлэх ухаан технологийн төсөл, суурь болон хавсарга судалгааны ажлын гүйцэтгэгчээр ажиллах чадвар, арга зүй эзэмшсэн байх;
 - 1.2.5. Компьютер, техник, хэрэгслийг хэрэглээний түвшинд бүрэн эзэмшсэн байх;
 - 1.2.6. Тухайн ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу 2-оос доошгүй гадаад хэлийг эзэмшсэн байх;
 - 1.2.7. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, бусдыг үлгэрлэн манлайлах, зөвлөн чиглүүлэх чадвартай байх.
 - 1.2.8. Сурах бичиг, гарын авлага, ном, нэг сэдэвт бүтээл бичиж байсан туршлагатай байх;
 - 1.2.9. Аливаа баримт бичгийг стандарт, шаардлагын дагуу үг, үсэг, утга найруулгын алдаагүй боловсруулах чадвартай байх.
- 1.3. Офицерын орон тоонд эрдэм шинжилгээний ажилтанд тавигдах шаардлага:
 - 1.3.1. Магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
 - 1.3.2. Эрдэм шинжилгээний ажил явуулах мэдлэг, чадвараа дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх;
 - 1.3.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл 3-аас доошгүй бичиж нийтлүүлсэн байх;
 - 1.3.4. Компьютер, техник, хэрэгслийг хэрэглээний түвшинд бүрэн эзэмшсэн байх;
 - 1.3.5. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг байх;
 - 1.3.6. Гадаад хэлний 1-ээс доошгүй гадаад хэлний эзэмшсэн зохих мэдлэг чадвартай байх.
 - 1.3.7. Аливаа баримт бичгийг стандарт, шаардлагын дагуу үг, үсэг, утга найруулгын алдаагүй боловсруулах чадвартай байх.
- 1.4. Эрдэм шинжилгээний ажилтан
 - 1.4.1. Магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
 - 1.4.2. Эрдэм шинжилгээний ажил явуулах мэдлэг, чадвараа дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх;
 - 1.4.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл 3-аас доошгүй бичиж нийтлүүлсэн байх;
 - 1.4.4. Компьютер, техник, хэрэгслийн хэрэглээний түвшинд бүрэн эзэмшсэн байх;
 - 1.4.5. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг байх;
 - 1.4.6. Гадаад хэлний 1-ээс доошгүй гадаад хэлний эзэмшсэн зохих мэдлэг чадвартай байх.
 - 1.4.7. Аливаа баримт бичгийг стандарт, шаардлагын дагуу үг, үсэг, утга найруулгын алдаагүй боловсруулах чадвартай байх.

1.5 Туршилт, судалгааны лабораторийн даргад тавигдах шаардлага:

- 1.5.1 Цэргийн ухааны доктор (Ph.D) ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй,
- 1.5.2 Цэргийн мэргэжлийн дээд боловсролтой
- 1.5.3 Шинжлэх ухаан технологийн төсөл, суурь болон хавсарга судалгааны ажлын гүйцэтгэгчээр ажиллах чадвар, арга зүй эзэмшсэн байх;
- 1.5.4 Компьютер, техник, хэрэгслийг хэрэглээний түвшинд бүрэн эзэмшсэн байх;
- 1.5.5 Тухайн ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу 2-оос доошгүй гадаад хэлийг эзэмшсэн байх;
- 1.5.6 Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, бусдыг үлгэрлэн манлайлах, удирдан чиглүүлэх чадвартай байх;
- 1.5.7 Сурах бичиг, гарын авлага, ном, нэг сэдэвт бүтээл бичиж байсан туршлагатай байх;
- 1.5.8 Аливаа баримт бичгийг стандарт, шаардлагын дагуу үг, үсэг, утга найруулгын алдаагүй боловсруулах чадвартай байх.

1.6. Мехатроник ба хиймэл оюун хөгжүүлэлтийн тасгийн даргад тавигдах шаардлага:

- 1.6.1 Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- 1.6.2 Программ хангамж, автоматжуулалт, удирдлагын системийн инженерийн мэргэжилтэй, судалгаа, шинжилгээний арга зүй эзэмшсэн байх;
- 1.6.3 Шинжлэх ухаан технологийн төсөл, суурь болон хавсарга судалгааны ажлын гүйцэтгэгчээр ажиллах чадвар, арга зүй эзэмшсэн байх;
- 1.6.4 Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай.
- 1.6.5 Тухайн ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу 1-ээс доошгүй гадаад хэлийг эзэмшсэн байх;
- 1.6.6 Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, бусдыг үлгэрлэн манлайлах, зөвлөн чиглүүлэх чадвартай байх;
- 1.6.7 Сурах бичиг, гарын авлага, ном, нэг сэдэвт бүтээл бичиж байсан туршлагатай байх;
- 1.6.8 Аливаа баримт бичгийг стандарт, шаардлагын дагуу үг, үсэг, утга найруулгын алдаагүй боловсруулах чадвартай байх.

1.7. Нисгэгчгүй нисэх хэрэгслийн тасгийн даргад тавигдах шаардлага:

- 1.7.1 Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- 1.7.2 Цэргийн зэвсэглэл, техникийн ухаан, нисэхийн технологи, техник судлалаар мэргэшсэн, судалгаа, шинжилгээний арга зүй эзэмшсэн байх;
- 1.7.3 Шинжлэх ухаан технологийн төсөл, суурь болон хавсарга судалгааны ажлын гүйцэтгэгчээр ажиллах чадвар, арга зүй эзэмшсэн байх;
- 1.7.4 Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай.
- 1.7.5 Тухайн ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу 1-ээс доошгүй гадаад хэлийг эзэмшсэн байх;

- 1.7.6 Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, бусдыг үлгэрлэн манлайлах, зөвлөн чиглүүлэх чадвартай байх;
 - 1.7.7 Сурах бичиг, гарын авлага, ном, нэг сэдэвт бүтээл бичиж байсан туршлагатай байх;
 - 1.7.8 Аливаа баримт бичгийг стандарт, шаардлагын дагуу үг, үсэг, утга найруулгын алдаагүй боловсруулах чадвартай байх.
- 1.8. Инженерт тавигдах шаардлага:
- 1.8.1 Техникийн ухааны Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
 - 1.8.2 Электроник, механик, автоматжуулалт, программ хангамж, материал судлалын чиглэлээр инженер мэргэжилтэй байх;
 - 1.8.3 Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллага, Зэвсэгт хүчний анги, салбар, цэргийн мэргэжлийн боловсролын байгууллага, төр, хувийн хэвшлийн байгууллагад 1-ээс дээш жил ажилласан, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай байх;
 - 1.8.4 Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай.
 - 1.8.5 Тухайн ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу 1-ээс доошгүй гадаад хэлийг эзэмшсэн байх.
 - 1.8.6 Аливаа баримт бичгийг стандарт, шаардлагын дагуу үг, үсэг, утга найруулгын алдаагүй боловсруулах чадвартай байх.

Хоёр. Сонгон шалгаруулалт зохион байгуулах

- 2.1 Энэхүү журамд заасан сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө дараах байж болох боломжийг анхааран авч үзнэ. Үүнд:
- 2.1.1 Ажлын байрыг боловсронгуй болгох эсвэл хасаж болох эсэхийг судлах;
 - 2.1.2 Байгаа ажиллагсдадаа тухайн ажил үүргийг тараан хуваарилж болох эсэхийг судлах;
 - 2.1.3 Энэ ажлыг гүйцэтгэж чадах дараагийн туршлагатай ажилтанд ажил үүргийг шилжүүлж болох эсэхийг судлах;
 - 2.1.4 Ажлын ачааллыг харгалзан тухайн ажлын байранд хагас цагаар ажилладаг, эсвэл түр ажилтныг ажиллуулж болох эсэхийг судлах;
 - 2.1.5 Сул ажлын байранд өөрсдийн ажиллагсад дотроос нэр дэвшигчгүй тохиолдолд гаднаас шинэ ажилтныг сонгон шалгаруулах чиглэл баримтлан ажиллах
 - 2.1.6 Сонгон шалгаруулалтад ашиглаж буй шалгалтын материал болон үнэлгээний арга аргачлал, ажил горилогчийн хувийн нууцтай холбоотой мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах;
- 2.2 Хүрээлэнгийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд байгууллагын стратеги зорилтуудтай уялдуулан тухайн жилээр нь багцаалж гаргах ба шаардлагатай тохиолдолд улирлаар тодотгол хийж байна.

- 2.3 Захиргааны удирдлагын нэгж БХЯ-наас баталсан бүтэц, орон тоонд үндэслэн эхлээд ажилтан албан хаагч авах хэрэгцээ, шаардлагын үндсэн дээр сул болон шинээр бий болсон ажлын байрыг дотооддоо зарлан, сонгон шалгаруулалт хийнэ.
- 2.4 Хүрээлэнгийн сул орон тоо, сонгон шалгаруулалтыг тухай бүр хүрээлэнгийн цахим хуудсанд зар тавигдаж ажилд орохоор хүсэлт гаргасан иргэн (цэргийн алба хаагч)-ий материалыг захиргааны удирдлагын нэгж хүлээн авч, сонгон шалгаруулах комиссыг хүрээлэнгийн захирлын тушаалаар байгуулна;
- 2.5 Сонгон шалгаруулах комисс буюу ажлын хэсэг нь уг үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд.
- 2.5.1 Оролцогч талуудын эрх үүргийг хангаж, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шударгаар зохион байгуулна;
- 2.5.2 Ажил горилогчийг нас хүйс, гарал угсаа, шашин шүтлэг, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол, үзэл бодол, хөрөнгө чинээтэй эсэхээс үл хамааран, ялгаварлалгүйгээр сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцуулна;
- 2.5.3 Шууд удирдлагаар харьяалах, харьяалагдах ажлын байранд гэр бүлийн гишүүн, төрөл садан, найз нөхдийг сонгон шалгаруулалтад оролцуулахгүй. Бусад ажилтан, албан хаагчаас санал болгосон садан, төрлийн хүн болон бусад ажил горилогч нь аливаа давуу эрх эдлэхгүй,
- 2.6 Шалгалт зохион байгуулах комиссын үйл ажиллагаа Үүнд:
- 2.6.1 Ажилтан, алба хаагчдыг сонгон шалгаруулах комиссыг захирлын тушаалаар тухайн оны 01 дүгээр сард багтаан батална.
- 2.6.2 Шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын комисст тухайн чиглэлийн мэдлэг, туршлагатай албан тушаалтныг оролцуулж болно.
- 2.6.3 Комисс нь сонгон шалгаруулалттай холбоотой аливаа асуудлыг хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх ба тухай бүрд нь хуралдааныг бэлтгэх, зохион байгуулах ажлыг комиссын нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулна,
- 2.6.4 Сонгон шалгаруулалт явуулах шалгалтыг ажлын байр тус бүрээр шалгалтын материалыг боловсруулан нууцлалыг хангах асуудлыг томилогдсон комисс хариуцах ба сонгон шалгаруулалттай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэнэ.
- 2.7 Сонгон шалгаруулалтын зар
- 2.7.1 Эрдэм шинжилгээний ажилтны сул орон тоонд ажилтан шалгаруулалт явуулах саналыг тухайн төвийн дарга бэлтгэн БХЭШХ-ийн захирлаас зөвшөөрсөн тохиолдолд захиргааны удирдлагын албаны дарга хариуцан зар тавина.
- 2.7.2 Зарыг сонгон шалгаруулалт явуулахаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө тус хүрээлэнгийн цахим хуудас болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана.
- 2.7.3 Зарын агуулгад ажлын байрны нэр, албан тушаалын зэрэглэл, тавигдах ерөнхий шаардлага, ажлын байрын тоо бүрдүүлэх

материал, материал хүлээн авах хугацаа, лавлагаа мэдээлэл өгөх албан тушаалын утасны дугаар, материал хүлээн авах газ, байршил зэргийг товч ойлгомжтой байдлаар тусгана.

2.8 Бүртгэх:

2.8.1 Бүртгэлийг комиссын нарийн бичгийн дарга зар тавигдсан хугацаанд бүртгэж, материалын бүрдлийг шалгаж, оролцогч бүрд дүнгийн хуудас /хавсралт-2/ хөтөлсөн байна.

2.8.2 Сонгон шалгаруулалтад оролцогчдоос дараах материал бүрдүүлсэн байна.

2.8.2.1 Өргөдөл;

2.8.2.2 Төрийн албан хаагчийн анкет;

2.8.2.3 Боловсролын зэргийг гэрчилсэн баримт /дипломууд/ Иргэний болон офицер, ахлагчийн үнэмлэхийн хуулбар;

2.8.2.4 Эрүүл мэндийн магадалгаа;

2.8.2.5 Оршин суугаа хорооны болон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

2.8.2.6 Сонгон шалгаруулалтад орохыг зөвшөөрсөн ажиллаж буй байгууллагын бичгээр гарсан зөвшөөрөл;

2.8.2.7 Бүтээлийн жагсаалт (баталгаажсан)

2.8.2.8 Иргэний үнэмлэхийн хуулбар

2.8.2.9 Цээж зураг 2 хувь (3 х 4)

2.8.2.10 Бусад шаардлагатай бичиг баримт

2.9 Сонгон шалгаруулалтын шалгалтын төрөл, хэлбэр

2.9.1 Шалгаруулалт нь дараах хэсгээс бүрдэнэ.

2.9.1.1 Ерөнхий болон мэргэжлийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалт

2.9.1.2 Ур чадварын түвшин тогтоох шалгалт

2.9.1.3 Гадаад хэлний шалгалт

2.9.1.4 Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох ярилцлага

2.9.1.5 Сэтгэл зүйн тест

2.10 Ерөнхий (боловсрол, шинжлэх ухааны болон төрийн албаны тухай хууль эрх зүйн мэдлэг) болон мэргэжлийн мэдлэгийн шалгалтыг бэлтгэсэн тест хэлбэрээр авч шалгаруулна.

2.11 Ур чадварын түвшин тогтоох шалгалтыг өрсөлдөгчдөөс тодорхой сэдвүүдээр эсээ бичүүлэх хэлбэрээр тус тус зохион байгуулна. Мөн комиссын зүгээс өөр хэлбэрээр /эсээ бичүүлэх, орчуулга хийлгэх, богино ярилцлага хийх гэх мэт/ шалгалт авч болно.

2.12 Гадаад хэлний шалгалтыг англи, орос эсвэл шалгуулагчийн сайн эзэмшсэн хэлээр шалгалт авах ба англи, орос хэлний хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын оноотой бол түүнийг орлуулан тооцож болно.

2.13 Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох ярилцлагын шалгалтыг хүснэгтийн /хавсралт-3/ тусгай бэлтгэсэн асуултаар болон гишүүдийн сонгосон сэдвээр харилцан ярилцах замаар оноо өгч шалгаруулна.

- 2.14 Сонгон шалгаруулалтыг явуулахдаа дээрх шалгалтын дарааллыг баримтлах ба ерөнхий болон мэргэжлийн түвшин тогтоох шалгалтын босго оноо хангаж тэнцсэн иргэний ур чадварын, энэхүү шалгалтын оноог хангаж тэнцсэн иргэнийг гадаад хэлний, энэхүү шалгалтын босго оноог хангасан иргэнийг мэдлэг хандлага, зан үйлийг тодорхойлох ярилцлага шалгалтуудад оруулна
- 2.15 Комисс дүнг цаг тухайд нь оролцогчид мэдэгдэн, дүнгийн хуудас /хавсралт-2/-ыг хөтөлнө.

Гурав. Сонгон шалгаруулалтын дүн гаргах, баталгаажуулах

- 3.1. Комисс нь 3 дахь шатны шалгалтад хамгийн өндөр оноо авсан 2 болон түүнээс дээш албан хаагчдыг сонгон шалгаруулахдаа ойролцоо оноотой бол "Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох" шалгалтын оноог чухалчлан үзнэ.
- 3.2. Эцсийн шийдвэрийг онооны дарааллыг үндэслэн комиссын бүрэлдэхүүний олонхын саналаар батлан шийдвэрлэнэ
- 3.3. Шийдвэрийг оролцогчид танилцуулан, сонгон шалгаруулалтын дүнгийн хуудсыг танилцуулж гарын үсэг зуруулна.
- 3.4. Комиссын шийдвэр гарч, тэнцсэн иргэн, алба хаагчийг тухайн албан тушаалд дэвшүүлэх саналыг холбогдох материалын хамт ажлын 5 өдөрт багтаан захиргаа, дэмжлэгийн албанд ирүүлнэ.
- 3.5. Сонгон шалгаруулалтад тэнцсэн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэх ба албан тушаалд томилох үйл ажиллагааг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар эцэслэн шийдвэрлэнэ.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

НЭГ. ОРОЛЦОГЧ

Овог, нэр:

Регистрийн дугаар

ХОЁР. АЖИЛЛАХЫГ СОНИРХОЖ БУЙ

Төв

Албан тушаал

ГУРАВ. ШАЛГАЛТЫН ДҮН

№	Шалгалтын төрөл	Шалгалт өгсөн огноо	Авбал зохих дээд оноо	Авсан оноо
1.	Ерөнхий ба мэргэжлийн түвшин тогтоох шалгалт		30	
2.	Ур чадварын шалгалт		30	
3.	Гадаад хэлний шалгалт		20	
4.	Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох шалгалт		20	

ДҮНТЭЙ ТАНИЛЦСАН:

/гарын үсэг, нэр/

БАЙНГЫН КОМИССЫН ДАРГА:

/гарын үсэг, нэр/

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

**МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЗАН ҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛОХ
ШАЛГАЛТЫН ДҮНГИЙН ХҮСНЭГТ**

№	Үзүүлэлт	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээ			Дундаж оноо
		1 дэх гишүүн	2 дахь гишүүн	3 дахь гишүүн	
1.	Ажиллах байгууллага, төв, ажлын байрны зорилго, зорилт чиг үүргийн талаарх ерөнхий төсөөлөл				
2.	Батлан хамгаалах салбарын бодлого, зорилт, цэргийн боловсрол, ШУ-ны талаарх ерөнхий мэдлэг				
3.	Тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай мэдлэг, туршлага				
4.	Тухайн албан тушаалыг хаших сонирхол, эрмэлзэл хандлага				
5.	Зан байдал, багаар ажиллах, баг бүрдүүлэх чадвар				
НИЙТ ҮНЭЛГЭЭ					

Үнэлгээний шатлал: Маш сайн-4, Сайн-3, Дунд-2, Хангалтгүй-1 оноо

ДҮГНЭСЭН:

1 ДЭХ ГИШҮҮН:/огноо/.....

2 ДАХЬ ГИШҮҮН:/огноо/.....

3 ДАХЬ ГИШҮҮН:/огноо/.....

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН